



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Ш.БУЛГА-ЭРДЭНЭ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.05.09 № 01/46 ЧАТ-Т/А/2014/01-Т/А

**ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ**

Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

2012 онд ашиглалтад орсон 6,168.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Багшийн хөгжлийн ордны гүйцэтгэгчээр “Санбо констракшн” ХХК шалгарч барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан байна.

Гэвч барилгын ажлыг чанаргүй гүйцэтгэснээс 2013 онд тус барилгад улсын төсвөөс дахин хөрөнгө гаргаж 43.0 сая төгрөгийн засварын ажлыг “Оюун санаа констракшн” ХХК гүйцэтгүүлсэн нь Барилгын тухай хуулийн 12.4-т “Барилгын чанарын баталгаат хугацаа гурван жил байна” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”,

Барилгын тухай хуулийн 16.1.3-т “барилга байгууламжийн чанарын баталгаат хугацаа дуусаагүй байхад өөрийнх нь буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн чанарын зөрчлийг өөрийн зардлаар арилгах”,

“Санбо констракшн” ХХК-тай байгуулсан ЗТ-БУА-01/2009 тоот гэрээний 7-д “гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна” гэж заасныг тус тус үндэслэн чанаргүй барилга ашиглалтад оруулснаас улсын төсвийн хөрөнгөөр дахин хийгдсэн 43.0 сая төгрөгийг “Санбо констракшн” ХХК-иар төлүүлж Улсын төсвийн орлого болгон, 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор хариу мэдэгдэхийг БШУЯамны Төрийн нарийн бичгийн дарга Ш.Булга-Эрдэнэ, БШУЯамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ц.Баярхүү, “Санбо констракшн” ХХК-ийн ерөнхий захирал Уан Сил Ро нарт үүрэг болгож албан шаардлага хүргүүлж байна.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Д.ГАНДОЛГОР

Э.УЯНГА

УХА0122